



Хэвлэлийн мэдээ  
2016 оны 8-р сарын 8

Холбоо барих:  
9710-9009

## Тэгш боломж бүхий бизнесийн таатай орчин бий болгох нь:

### Гарал үүслийн гэрчилгээний асуудал

Монгол улсын бизнес эрхлэгчдийн ашиг сонирхлын төлөөлөгчдийн нэг Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам) нь Монгол улсын эдийн засгийг тогтворжуулах, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх болон хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих хөтөлбөртэйгөөр УИХ –ын сонгуульд ялалт байгуулан төрийн эрх мэдлийг удирдах болсон Монгол Ардын Намд баяр хүргэж байна.

Гэвч 2016 оны 6-р сарын эхээр Гаалийн Ерөнхий Газраас Монгол улсын хилээр импортоор орж ирж буй бүх бараа бүтээгдэхүүн нэн тааламжтай тариф (НТТ)-аар татвар төлөхийн тулд Гарал үүслийн гэрчилгээ (ГҮГ)-г эх хувиар бүрдүүлэх ёстой хэмээх шинэ журмыг санаачлаад байна. Урд нь Монгол улсын гааль зөвхөн хортой гэсэн төрлийн бараа, бүтээгдэхүүнд энэхүү гэрчилгээг хавсаргахыг шаарддаг байсан. Монгол улсад бараа бүтээгдэхүүн импортлогчид, дотоодын бизнесийн байгууллагууд болон хэрэглэгч, худалдан авагчдад олон төрлийн бэрхшээл учруулах энэхүү журам 2016 оны 10-р сарын 1-ний өдрөөс хэрэгжихээр төлөвлөгдөөд байна.

Энэхүү журмыг гаргах үндэс суурь нь Монгол Улс, Япон Улс хоорондын “Эдийн засгийн түншлэл”-ийн тухай хэлэлцээр байсан бололтой. Тус хэлэлцээрийн дагуу Япон улсаас Монгол улсад орж ирэх бараа бүтээгдэхүүн гаалийн татвараас чөлөөлөгдөх эсвэл бага татвар төлөхийн тулд ГҮГ-г эх хувийг бүрдүүлсэн байхыг шаардаж байгаа. Харин Япон улсын хувьд зөвхөн худалдааны давуу талыг хүсч буй бараа бүтээгдэхүүн л энэхүү гэрчилгээг бүрдүүлэхийг шаарддаг. Монгол улсын гаалиар орж ирэх бүх бараа бүтээгдэхүүнд ГҮГ-г эх хувийг хавсаргахыг шаардах нь бизнесүүдэд таатай, шударга биш төдийгүй үр ашиггүй юм.

Мөн түүнчлэн Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) гишүүн орнууд руугаа орж ирж буй импортын бараа бүтээгдэхүүнүүд хөнгөлөлттэй тариф авахгүй тохиолдолд ГҮГ-г эх хувийг бүрдүүлсэн байх ёстой гэж шаарддаггүй. ДХБ-ний дүрмийн дагуу Монгол Улс, Япон Улс хоорондын “Эдийн засгийн түншлэл”-ийн тухай хэлэлцээрийн адил худадааны хэлэлцээрүүдийн дагуу тогтоогдсон хөнгөлөлттэй тариф нь бусад нэн тааламжтай тарифт нөлөөлөх буюу саад тогтор, бэрхшээл болох ёсгүй гэсэн байдаг. Гэвч энэхүү шинэ журам нь Монгол улс руу бараа, бүтээгдэхүүн импортолж буй ДХБ-ийн бүх гишүүн орнуудын хувьд буюу Япон улсаас бусад бүх улсуудад томоохон хүндрэл учруулах болно.

Удахгүй хэрэгжиж эхлэх энэ журмын хэрэгжилтээс үүдэн гарах олон сөрөг үр дагаврууд байна. Үүнд:

1. ДХБ-ын 163 гишүүн орон Монгол улс руу бараа, бүтээгдэхүүн нэн тааламжтай тарифаар импортлохын тулд ГҮГ-г бүрдүүлэх шаардлагатай болж байгаа нь Монгол улстай чөлөөт худалдааны гэрээгүй орнуудыг шударга бусаар ялгаварлаж буй үйлдэл болж байна
2. Журмаас үүдэн бусад улс орнуудаас ирж болох сөрөг хариу үйлдлээс шалтгаалан Монгол улсын экспортын бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар болон эрэлт хэрэгцээ багасах эрсдэлтэй байх болно

3. Хөнгөлөлттэй тариф авахгүй бүх импортлогчдод томоохон хүндрэл учруулж, импортын зардлыг өсгөх ба энэхүү нэмэлт зардал нь Монгол улсын хэрэглэгч, худалдан авагчдын нуруун дээр буух магадлалтай юм
4. Тээвэрлэлтийн хугацаанд шаардлагагүйгээр 4-5 хоног нэмэх ба энэ нь импортын бараа бүтээгдэхүүн оруулж ирж буй бизнесүүдэд томоохон хохиролтой. Жишээ нь уул уурхайн компаниудын хувьд тээвэрлэлт хойшилсноор үйлдвэрлэл сая сая тонноор тасрах, орлого буурах цаашлаад улсад төлөх татвар буурах зэрэг сөрөг нөлөөлөл гарах ба эдгээр нь уул уурхайн салбарын хөгжлийг дэмжиж, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна
5. Мөн энэхүү журмыг хэрэгжүүлснээр Монгол улсын гаалийн ерөнхий газарт хүн хүч ихээхэн хэрэг болох ба энэ хүний нөөцийн зардал болон үйл ажиллагааны зардлыг өсгөх магадлалтай юм.

Мөн түүнчлэн энэхүү шинэ журам нь Гаальд ажиллаж буй мэргэжилтнүүдэд тухайн бараа, бүтээгдэхүүн нь нэн тааламжтай тариф (НТТ)-г хамаарах эсэхийг шийдэх өөрөөр хэлбэл энгийн тариф буй НТТ-аас хоёр дахин их татварыг тухайн бараа бүтээгдэхүүнд гаалиар нэвтрэхээс нь өмнө ногдуулах эрх мэдлийг олгож магадгүй байдлаар бичигдсэн байна. Энэ нь ойрын хэдэн жилд Гаалийн ерөнхий газрын зүгээс авч хэрэгжүүлсэн авлигалын эсрэг олон чухал санаачлагуудыг үгүй хийж магадгүй байна.

Бид Монгол улсын Засгийн газар, УИХ-г энэхүү журмыг дахин хэлэлцэж цуцлан зөвхөн хортой ангилалд орох мөн хөнгөлөлттэй тариф авахыг хүсч буй импортын бараа бүтээгдэнүүдэд ГҮГ-г эх хувийг шаарддаг болгохыг уриалж байна. Ингэж чадсанаар бид олон улсын худалдаа арилжааны цэвэр, шударга харилцааг дэмжин гадны хөрөнгө оруулагчдад эерэг ойлголтыг төрүүлээд зогсохгүй дотоодын компаниуд болон хэрэглэгч, худалдан авагчдаа шаардлагагүй зардлаар нэмэлт дарамт бий болгохгүй бөгөөд Монгол улсад илүү таатай бизнесийн орчинг бүрдүүлж чадах болно.

### **АмЧам Монголын тухай**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.